

Засгийн газраас баталсан” Иод дутлын эмгэгтэй тэмцэх”  
 III хөтөлбөрийн хэрэгжилтийн явцад хийсэн  
 хяналт-шинжилгээ, үнэлгээний тайлан

2009 оны жилийн эцсийн байдлаар

№	Хөтөлбөрийн агуулга		Гүйцэтгэл							
1	Хөтөлбөрийг баталсан Засгийн газрын тогтоолын дугаар, огноо		Засгийн газрын тогтоол, 2007.04.04, № 85							
2	Хөтөлбөрийн зорилго		Хүн амыг чанартай, аюулгүй иоджуулсан үндэсний үйлдвэрлэлийн давсаар хангах хэмжээг нэмэгдүүлэх, хэрэглээг тогтмолжуулан хэвшүүлэх замаар иод дутлын эмгэгийн тархалтыг 5-аас доош, иоджуулсан давсны хэрэглээг 95-аас дээш хувьд хүргэх, иоджуулсан тэжээлийн үндэсний үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх замаар малын иод дутлын эмгэгийг бууруулах.							
3	Хөтөлбөрийн зорилтууд /Үе шатны хугацаатай нь авч үзэх/	2007-2010 он	1. Давсны ордыг эзэмшилтэй болгох, иоджуулсан давс, эрдэс тэжээл, эм бэлдмэлийн үндэсний үйлдвэрлэлийг өргөжүүлэх, техник технологийн шинэчлэл нэвтрүүлэх ажлыг бодлогоор дэмжинэ. 2. Иоджуулсан хүнсний давс болон малын тэжээл бэлдмэлийн үйлдвэрлэл, хангамж, хэрэглээ, үйлчилгээг хянах, мэдээлэх тогтолцоог боловсронгуй болгоно. 3. Хүн, малын иод дутлын эмгэгийг хянах тандалтыг тогтворжуулна. 4. Иод дутлын эмгэгийн талаархи хүн амын мэдлэгийг дээшлүүлэх сургалт, сурталчилгааг тогтмолжуулах, мэдээллийг хүртээмжтэй болгох замаар иоджуулсан давсны хэрэглээг хэвшүүлнэ.							
4	Зардал /сая төг/	Төсөв /шаардагдах нийт зардал/	Эх үүсвэр: 1. Улсын болон орон нутгийн төсөв, 2. Хандивлагч орон, олон улсын байгууллагын зээл тусламж, 3. Жижиг дунд үйлдвэрийг хөгжүүлэх сан, 4. Иргэд, аж ахуйн нэгж, байгууллагын хандив, тусламж, 5. Гадаад, дотоодын хөрөнгө оруулалт Зарцуулах хөрөнгийн хэмжээг тогтоогоогүй болно							
		Гүйцэтгэл /өссөн дүнгээр/	91.3 сая төгрөг							
		Үүнээс тухайн жилд зарцуулсан	17.3 сая төг							
5	Хөтөлбө-рийн хэрэгжилтийн үнэлгээ	Биелэлтийн хувь	Дүн	100	90	70	50	30	10	0
		Хөтөлбөрт дэвшүүлсэн зорилтын тоо	4		2	2				
6	Шалгуур үзүүлэлтийн гүйцэтгэл		Төлөвлөсөн	Гүйцэтгэл				Хувь		
	Шалгуур үзүүлэлт тус бүрээр	7-11 насны хүүхдүүдийн дундах бахлуу-рын тархалтын хувь	5.0	12.8				39.1		
		7-11 насны хүүхдүүдийн шээсэн дэх иодын агууламж 100мкг/л-ээс бага байх хувь	50.0	30.4				164.5		

		Нярайн цусан дахь БЭД оун/мл-ээс их байх хувь	4.0	Судалгаа хийгдээгүй	-
		Өрхийн түвшин дэх иоджуулсан давсны хэрэглээний хувь	95.0	93.5	98.4
		Иоджуулсан хүнсний давсны хангамж	100.0	100.0	100.0
		Иоджуулсан эрдэс тэжээлийн үйлдвэр	3	3	100.0
		Малын ИДЭ-ийн тархалтын хувь	10.0	8.1	123.4
7	Хөтөлбөрийн гол үйл ажиллагаа, гарц	<p>2009 оны хөтөлбөрийн санхүүжилтийг давсны томоохон үйлдвэр байгуулах ТЭЗҮ боловсруулах, судалгаа хийх/16%/, сургалт, сурталчилгаа, стандартын хяналт хийх/43.2%/, үндэсний өдөр тэмдэглэх, үзэсгэлэн, олон улсын хуралд оролцох/34.3%/, удирдах зөвлөлийн хурал, бичиг хэрэг, дотоод ажлын зардал/6.5%/ зэрэг үйл ажиллагаанд зарцуулжээ.</p> <p>2008 оны эцсийн мэдээгээр дотоодын үйлдвэрлэгчид 930,9 тонн иоджуулсан давс үйлдвэрлэж, 779,4 тонныг борлуулсан, импортлогч аж ахуйн нэгжүүд 8902,5 тонныг гадаадаас оруулж, 7172,5 тонныг борлуулсан дүнтэй байна. Тайлант онд нийт 7951,9 тонн иоджуулсан давс борлуулжээ. 2009 онд дотоодын иоджуулсан давсны үйлдвэрлэл 22.5%, импортолсон давс 34.4%-иар тус тус буурчээ.</p> <p>Иоджуулсан малын тэжээлийн улсын стандартын төсөл боловсруулсан. "Иод дутлын эмгэгийн тархалтын хяналтын судалгаа" тайлан. 2008 он.</p> <p>"Малын иод дутлын эмгэгийн тархалтыг үндэсний хэмжээнд төл малд судлан тогтоох" сэдэвт судалгааны ажлын тайлан. 2008 он.</p> <p>2007 онд давс үйлдвэрлэгчдийн сургалт-семинарит 18 хүн, 2008 онд дотоод хяналтын лаборантууд, булчирхайн эмч, мэргэжлийн хяналтын байцаагч, лабораторын шинжээч, үйлдвэрлэгчдийн бүсчилсэн сургалт-семинарит 71 хүнийг сургасан.</p>			
8	Дүгнэлт /хөтөлбөрийн хэрэгжилтийн үр дүн, үр ашиг, үр өгөөж/	<p>"Иод дутлын эмгэгтэй тэмцэх" (2007-2010 он) III хөтөлбөрийн хэрэгжилтэд хийсэн үнэлгээг үндэслэн уг хөтөлбөр төлөвлөсний дагуу хэрэгжиж байгаа боловч хөтөлбөрийн үйл ажиллагааны жилийн төлөвлөгөө, тэдгээрийн төсвийн төлөвлөлтийн чанарыг сайжруулж үр ашгийг дээшлүүлэх шаардлагатай байна.</p> <p>Хөтөлбөрийн ач холбогдол өндөр, үр дүн нь төлөвлөсөн хэмжээнд гарах хандлагатай, эдгээр нь хөтөлбөрийн үр нөлөөг бий болгоход үндсэндээ чиглэгдэж байна. 2009 онд хөтөлбөрийн үйл ажиллагаа нь өмнө бий болгосон үйлдвэрлэл, хэрэглээний үр дүнг тогтворжуулах, дотоодын үйлдвэрүүдийн бүтээгдэхүүний чанарыг сайжруулахад түлхүү анхаарсан байна.</p>			
9	Хүлээгдэж буй үр дүндээ хүрээгүй бол шалтгаан, нөлөөлсөн хүчин зүйлс, гарсан гажуудал	<p>Үр дүнгийн тогтвортой байдлын хувьд дотоодын иоджуулсан давс үйлдвэрлэгчдийн өрсөлдөх чадварыг дээшлүүлэх, давсны чанарыг сайжруулах, татварын бодлогоор дэмжих замаар тэдгээрийн тогтвортой үйл ажиллагааг бэхжүүлэхэд түлхүү анхаарах шаардлагатай байна. 2009 онд иоджуулсан давсны үйлдвэрлэл буурсан</p>			

		нь эдийн засгийн хямралтай холбоотой байна. Хөтөлбөрийн санхүүжилт 2009 онд 3 дахин буурсан хөтөлбөрийн хүрээнд хийх ажлыг хязгаарлаж байна.
10	Эдгээрээс гарах арга зам	Орчин үеийн технологитой иоджуулсан давсны томоохон үйлдвэр байгуулах талаар хөтөлбөрт дэвшүүлсэн зорилтыг хэрэгжүүлэх, энэ талаар 2011 оны улсын төсөвт хэрэгжүүлэх. Иоджуулсан давсны тухай хуулийн хэрэгжилтийг хангах талаар анхаарч ажиллах
11	Хөтөлбөр хэрэгжүүлэхэд оролцогч талуудын талаархи үнэлгээ	Хөтөлбөрийн удирдлага зохицуулалт, оролцогч талуудын хамтын ажиллагаа сайн байна. Гэхдээ орон нутгийн төр, захиргааны байгууллагуудтай хамтын ажиллагааг эрчимжүүлэх шаардлагатай.
12	Хөтөлбөрийн талаарх яамны санал / өөрчлөн сайжруулах болон бодлогод үзүүлж буй хөтөлбөрийн дэмжлэгийг нэмэгдүүлэх талаар гэх мэт/	Хөтөлбөрийн үр дүнг тогтвортой хадгалахын тулд давс олборлогчид, үйлдвэрлэгчдэд татварын таатай орчин бүрдүүлэх, иоджуулсан давсны дотоодын үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх талаар санхүү, эдийн засгийн бодитой дэмжлэг үзүүлэх
13	Хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд орон нутгийн төрийн байгууллагуудын оролцооны талаархи санал/дэд хөтөлбөртэй байх, тухайн аймаг заавал хэрэгжүүлэх шаардлага байгаа эсэхийг тодорхойлох гэх мэт/	Энэ хөтөлбөрийн хүрээнд аймгууд дэд хөтөлбөртэй, нийслэл төлөвлөгөөтэй ажиллаж байна. Дэд хөтөлбөр, төлөвлөгөөг хэрэгжүүлэх санхүүгийн эх үүсвэрийг гаргахад орон нутгийн засаг захиргаа анхаарах. Мөн түүнчлэн хөтөлбөрийн орон нутгийн зохицуулагчид болон хөтөлбөрийн хүрээнд сургаж бэлтгэсэн чадавхийг тогтвортой ажиллуулах. Иоджуулсан давсны тухай хуулийг хэрэгжүүлэхэд орон нутгийн төрийн байгууллагуудын онцгой анхаарч ажиллах хэрэгтэй байна. Ингэвэл хөтөлбөрийг хэрэгжүүлэх явцад бий болгосон үр дүнг хэвээр хадгалах нэг чухал хүчин зүйл болно.

**Тайлбар:** Хөтөлбөрийн шалгуур үзүүлэлтүүдийн хүрсэн түвшинг үндэсний хэмжээний судалгаагаар тогтоодог тул энэ үнэлгээнд 2008 оны хүрсэн түвшинг хэвээр үлдээв,

ТӨРИЙН НАРИЙН БИЧГИЙН ДАРГА

Т.ГАНТУЛГА